



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 425

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын тусгай үйлчилгээний албаны автомашины техникийн үйлчилгээ, засварын байрны 3 ширхэг хаалгыг шинээр хийж гүйцэтгэх ИНЕГУЗ/ХББ/А-42/17 дугаар гэрээт ажлыг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Ц.Төрмөнх	Газрын тусгай үйлчилгээний албаны ерөнхий инженер
Гишүүд:	Г.Бат-Алдар	Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Цэдэв	Газрын тусгай үйлчилгээний албаны Техник үйлчилгээ, засварын хэлтсийн дарга
	Ж.Билэгсайхан	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны барилгын хяналтын инженер
	С.Оюунгэрэл	Газрын тусгай үйлчилгээний албаны Санхүү, бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч

2. Дээрх ажлыг техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээний шаардлагын дагуу шалгаж, гэрээний хэрэгжилтийг дүгнэн комиссын акт, холбогдох баримт бичгийг зохих журмын дагуу хүлээн авахыг ажил хүлээн авах комисс /Ц.Төрмөнх/-т даалгасугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН